

ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/12 дугаар анги удирдсан багшаас эцэг эхэд зориулсан сургалтын модуль/

Н. Мөнхчимэг

/Нийслэлийн 45-р сургууль сургалтын менежер/

munkhchimeg.n@school.edu.mn

Модулийн зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын эцэг эхэд ажил мэргэжлийн талаар АУБ-ийн зүгээс дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хэрэгжүүлэхэд нь арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Эрх зүйн барим бичиг:

БСШУ-ны Сайдын 2007 оны 351 дүгээр тушаалаар батлагдсан “ЕБС-ийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”-ын ажлын байрны үндсэн зорилтын 2-т багшийн бусад ажлыг гүйцэтгэхэд сурагчид, насанд хүрэгчидтэй ажиллах, сургалтаас гадуурх төрөл бүрийн үйл ажиллагаанд менежемент хийх, 1 дүгээр зорилтын хүрээнд сурагчдынхаа хэрэгцээ сонирхолыг судлах, 2 дугаар зорилтын хүрээнд эцэг эх, иргэд, олон нийттэй ажиллах гэж заасан.

БШУ-ны Сайдын 2020 оны А/199 дүгээр тушаалаар батлагдсан “ Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийн 3 дугаар хэсгийн 7 дугаар заалтад боловсролын байгууллагуудтай хүмүүжлийн асуудлаар хамтран ажилладаг, эцэг эхийн болон олон нийтийн бусад байгууллагын ажиллагааг хөхүүлэн дэмжих, 8 дугаар заалтад нийгмийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх гэж заасан

ХНХЯ болон БСШУСЯ-ны сайдын хамтарсан тушаалаар 2016 оны 6 сарын 24-ний өдөр “Ажил мэргэжлийг чиг баримжааг хөгжүүлэх” чиглэл гарсан.

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:

Хамгийн нэр хүндтэй, хамгийн хэцүү бөгөөд зайлж үл болох хариуцлага бол эцэг эх хүүхдийнхээ төлөө хүлээх хариуцлага юм.

Энэхүү модульд ажил мэргэжлийн чиг баримжааг 12 ангийн сурагчдад олгоход эцэг эхийн үүрэг, хариуцлага оролцоо чухал учраас 12 ангийн багшид зохион байгуулах үйл ажиллагааны үе шат бүрт эцэг эхтэйгээ хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөмжлөн хүргэж байна. Үүнд:

1. Ангийн менежментийн баг бүрэлдэхүүн байгуулж, ангийн ажлын, ХГҮА-ны зорилго, зорилт, төлөвлөгөө, хүрэх үр дүнгээ тодорхойлох, журам гаргах
2. Тус багт эцэг эхийн төлөөллийг оролцуулж, үүрэг, хариуцлага, оролцоог танилцуулах
3. Эцэг эхээс ажил мэргэжлийн чиг баримжааны ойлголтын талаар тандалт судалгаа авч, танхимын болон танхимын бус хэлбэрээр удирдлага, нийгмийн ажилтан,

номын санчтай хамтран сургалт зохион байгуулах, судалгаа, сорил авах, анализ дүгнэлт хийх

Тус сургалтаар дамжуулан эцэг эхэд:

- a. Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу болох, залуучууд тэдний эцэг эхэд ямар ач холбогдолтой талаар мэдээлэл өгөх /Гарын авлагууд болон холбогдох эх сурвалжуудыг ашиглах/
- b. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход эцэг эхийн үүрэг, хариуцлага, оролцоог танилцуулах Үүнд:

Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу болох залуучууд тэдний эцэг эхэд яагаад ач холбогдолтой талаар ойлголт

Хүний амьдралын хамгийн чухал сонголтын нэг нь ажил мэргэжлийн сонголт юм. Ажил мэргэжлээ зөв сонгосноор тухайн хүүхдийн амьдралын чанар, цаашилбал улс орны хөгжилд сайнаар нөлөөлнө.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хөдөлмөрийн зах зээл илүү төвөгтэй, өрсөлдөөнтэй болж, иргэдээс илүү өндөр түвшний ур чадвар, чадамж шаардах боллоо. Иргэд өөрийн сонирхол, ур чадвар, чадамж, эзэмшсэн мэргэжил болон хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн боловсрол, сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн сонголт хийх, ухаалаг шийдвэр гаргах, шийдвэр гаргахдаа янз бүрийн мэдээлэл ашиглах, эдгээр мэдээллийн үнэн зөв, шинэлэг байдалд дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд “Дээд боловсролтой боловч ажил хөдөлмөр эрхлэх мэргэжлийн ур чадваргүй” иргэдийн асуудал нэлээд түгээмэл байна. Гэтэл хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчид дээд боловсролтой гэхээс илүүтэй чадамжтай мэргэжлийн ажилчид хэрэгтэй байгаа талаар мэдээлсэн байдаг. Энэ асуудал ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чухал асуудлыг өөрийн эрхгүй хөндөхөд хүргэдэг.

Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу вэ?

ЕБС-ийн ахлах ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа нь суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах МБС-ын байгууллага болон их дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагаа юм.

Эцэг эхчүүд үр хүүхдийнхээ бага, дунд, мэргэжлийн эсвэл дээд боловсролд маш их хөрөнгө оруулалт хийж, хүчин чармайлт гаргасан боловч эцсийн дүндээ ажилгүй нөхцөл байдалд орох нь элбэг байна. Энэ нь тэдний урмыг их хугалдаг. Тэгвэл ЕБС-ийн ажил мэргэжлийн чиг баримжаа нь суралцагчид, тэдний эцэг эхэд хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн үеийн чиг хандлага, бодит нөхцөлд байдалд үндэслэсэн ухаалаг шийдвэр

гаргахад дэмжлэг үзүүлдэг бөгөөд ингэснээр тэднийг ажилгүй нөхцөл байдалтай тулгарахаас сэргийлнэ бас тэднийг бэлтгэнэ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа нь эцэг эхчүүд болон насан хүрэгчдэд харьцангуй шинэ ойлголт. Тэднийг суралцагч байхад ажил мэргэжлийн сонголт хийх, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа байдаггүй байсан. Тэдний зарим нь одоо эрхэлж байгаа ажил хөдөлмөр, эзэмшсэн мэргэжлээс өөр ажил мэргэжлийг илүүд үздэг. Тэдэнд ажил мэргэжлийн ухаалаг сонголт хийхэд дэмжих мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ тухайн үед байсангүй!

Иймээс эцэг эхчүүдийн үүрэг бол үр хүүхэд, залуу үеэ хөдөлмөрийн зах зээлийн бодит орчин, тодорхойгүй нөхцөл байдалд бэлтгэх явдал юм. Хүүхэд залуучууд ахлах ангийн хичээл, хөтөлбөр, МБС болон дээд боловсролын байгууллага, мэргэжлийн хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн талаар илүү мэдээлэлтэй байх тусам Монгол улс эдийн засгийн хувьд идэвхтэй, хөдөлгөөнтэй иргэдтэй байх боломжтой юм.

Хүүхэд залуучууд, тэдний эцэг эхийн шийдвэр гаргах чадамж харилцан адилгүй

- Бид бүхэн суралцагчид эзэмшсэн чадвар, сурлагын амжилт, нийгмийн, сэтгэл хөдлөлийн болон биеийн хөгжлийн хурдаараа, түүнчлэн ажил мэргэжлийн сонголт, ямар хичээл, хөтөлбөр энэ ажил мэргэжлийг эзэмших боломж олгох вэ гэдэг ойлголтоороо харилцан адилгүй байдаг гэдгийг мэднэ.
- Зөвхөн суралцагч хүүхдүүд гэлтгүй бүх хүмүүс ур чадвар, ажлын гүйцэтгэл болон ажил мэргэжлийн сонголттой холбоотой шийдвэр гаргахдаа өөр хоорондоо ялгаатай байдаг.
- **Ажил мэргэжлийн талаар шийдвэр гаргах чадамжийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх**
- Ажил мэргэжлийн чиг баримжааны үйл ажиллагаа нь бидний ажил мэргэжлийн болон боловсрол, сургалтын сонголтын талаар шийдвэр гаргах чадамжийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Ингэснээр бидний ажил, амьдралын илүү сайн үр дүн байх боломжтой юм. Энэ нь математикийн сургалт сайн байвал бид энэ шинжлэх ухааныг илүү сайн хэрэглэх, математиктай холбоотой асуудлыг илүү сайн гүйцэтгэх боломжтой байдагтай адил юм.
- **Эцэг эх, асран хамгаалагч болон насанд хүрэгчид хүүхэд, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх үүрэгтэй**
- Суралцагчдыг урт хугацааны ажил мэргэжлийн шийдвэрээ ухаалгаар гаргадаг, түүнийгээ үр дүнтэй төлөвлөдөг болгохын тулд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг илүү оновчтой бас үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй.
- **Иймээс эцэг эхчүүд бидний үүрэг бол үр хүүхэд, залуу үеэ хөдөлмөрийн зах зээлийн бодит орчин, тодорхойгүй нөхцөл байдалд бэлтгэх явдал юм.** Хүүхэд залуучууд ахлах ангийн хичээл, хөтөлбөр, МБС болон дээд боловсролын байгууллага, мэргэжлийн хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн талаар илүү мэдээлэлтэй байх тусам Монгол улс эдийн засгийн хувьд идэвхтэй, хөдөлгөөнтэй иргэдтэй байх боломжтой юм.

АНГИ	АЖИЛ МЭРГЭЖИЛТЭЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
12	<ul style="list-style-type: none"> - Ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх - Дээд боловсрол эсвэл мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэн суралцах хүсэлт гаргах - Зайны болон цахим сургалтын байгууллагад суралцах хүсэлт гаргах - Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд өөрийгөө бэлтгэх 	<ul style="list-style-type: none"> - Дээд боловсролын байгууллага, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, зайны болон цахим сургалтын байгууллагад элсэн суралцах хүсэлт хэрхэн гаргахыг мэдэх Дээрх сургалтын байгууллагыг үнэлж дүгнэх, эрэмбэлэх Дээр сургалтын байгууллагын мэргэжлийн хөтөлбөрийг үнэлж дүгнэх, эрэмбэлэх - Сонгосон хөтөлбөр болон сонирхсон ажил мэргэжлийн хоорондын холбоо хамаарлыг таньж мэдэх, хүйсийн онцлогийн талаар тогсон итгэл, үнэмшлийг мөн авч үзэх Энэ хөтөлбөрөө дүүргэсний дараа тохирох ажил хөдөлмөр эрхлэх боломжийг судлах, таньж мэдэх - Дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, зайны болон цахим сургалтын байгууллагад суралцах нөхцөл байдлыг таньж мэдэх, ойлгох - Хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэх талаар ойлголттой болох - Өөрийн хөдөлмөрлөх ур чадварыг удирдан чиглүүлж чаддаг байх - Ажилгүй нөхцөл байдлыг удирдах
Тус үйл ажиллагаанууд дээр эцэг эх хэрхэн оролцох талаар хэлэлцүүлэг хийж, хамтран ажиллах хэрэгтэй.		

2. ИРЭЭДҮЙГЭЭ ТӨЛӨВЛӨХӨД СУРАЛЦАГЧДАД ШААРДЛАГАТАЙ МЭДЛЭГ, ЧАДВАР

Ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх

ЕБС-ийн ахлах ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны явцад хүүхдүүд өөрсдийн ирээдүйн талаар төсөөлж, түүнийгээ төлөвлөх шаардлагатай болно. Өсвөр насны ямар ч хүүхдийн хувьд энэ бол амархан даалгавар биш. Ирээдүйгээ төлөвлөж сурахад тэдэнд тодорхой мэдлэг, чадвар шаардлагатай болно.

Ирээдүйгээ төсөөлж, төлөвлөхөд суралцагчдад дараах мэдлэг шаардлагатай. Үүнд:

- ✓ *Өөрийнхөө чадвар, ажил мэргэжлийн сонирхлын талаарх мэдлэг*
- ✓ Ажил мэргэжил, ажлын ертөнц, тодорхой ажил мэргэжилд тавигдах хувь хүний болон мэргэжлийн шаардлага, энэ ажил мэргэжлийг эзэмших боловсрол, сургалтын боломж болон ажлын хайлтын талаарх мэдлэг
- ✓ Бүх төрлийн сургалтын (өдрийн, эчнээ, оройн, зайны болон ЦОС) сонголтын талаарх мэдээлэл
- ✓ Их дээд сургууль, МБС, зайны болон ЦОС сургалтын хөтөлбөрийн агуулга
- ✓ Тухайн хөтөлбөрөөр суралцаж эзэмших мэргэжил, мэргэшил
- ✓ Сургалтын хугацаа, зардлын талаарх мэдлэг

- ✓ Тухайн хөтөлбөрийг дүүргэсний дараа ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх мэдлэг
- ✓ Ажилгүй нөхцөл байдлыг хэрхэн удирдахтай холбоотой мэдлэг чадвар
- ✓ Ажил хэрхэн хайх тухай мэдлэг
- ✓ Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхдээ яаж, хаанаас мэдээлэл олох тухай мэдлэг

12 дугаар анги ЕБС-ийн хамгийн сүүлийн жил байдаг учраас суралцагчдын гүйцэтгэх хамгийн эхний дасгал нь сургууль төгссөний дараа боловсрол, сургалт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн дор хаяж 8 боломж байдгийг таньж мэдүүлэхэд эцэг эхийн үүрэг чухал. Эдгээр 8 боломж нь:

- Төрийн болон хувийн өмчийн их дээд сургууль
- Төрийн болон хувийн өмчийн МБС-ын байгууллага, сургууль
- Төрийн болон хувийн өмчийн эчнээгээр эсвэл оройгоор сурч болох их дээд сургууль
- Төрийн болон хувийн өмчийн эчнээгээр эсвэл оройгоор сурч болох МБС-ын байгууллага, сургууль
- Зайны сургалт эсвэл ЦОС;
- Хөдөлмөр эрхлэх
- Хөдөлмөр эрхлэхгүй өөрөөр хэлбэл ажилгүй байх
- Түр хугацааны сонголт хийх

Бүх суралцагчид хэрэв эхний сонголт боломжгүй болвол дараа юу хийх вэ гэдэг төлөвлөгөө хийхэд эцэг эхийн дэмжлэг хэрэгтэй.

Дээрх мэдлэгийг хэрэглэхтэй холбоотой дараах чадвар зайлшгүй чухал. Юуны өмнө ажил мэргэжлийн оновчтой сонголт, ухаалаг, бодитой шийдвэр гаргах, энэ шийдвэрт нөлөөлөх нийгэм-эдийн засаг болон газарзүйн нөхцөл байдлын онцлогийг мэддэг байхын тулд суралцагчид ажил мэргэжил болон сургалтын талаарх хөндлөнгийн мэдээллийг тайлбарлаж, өөрийн мэддэг мэдээлэлтэй (өөрийнхөө талаарх мэдлэг, итгэл үнэмшил) уялдуулан хэрэглэж чаддаг байх хэрэгтэй.

Бид хөдөлмөрийн зах зээл, түүний ажил мэргэжлийн талаар хязгаарлагдмал ойлголт, мэдлэгтэй

Бидний мэдлэг хязгаартай. Эцэг эхчүүд бид бүхэн ажлын ертөнц, манай улсын хөдөлмөрийн зах зээлд байдаг бүх ажил мэргэжил, технологийн дэвшлийн нөлөөгөөр устаж үгүй болж байгаа ажил мэргэжил, шинээр гарч ирж байгаа ажил мэргэжлийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй. Ийм учраас бидний үр хүүхэддээ ажил мэргэжлийн талаар өгдөг санал, зөвлөгөө хуучирсан эсвэл хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон цаашдийн бодит нөхцөл, боломжуудыг орхигдуулсан шинж чанартай байдаг.

3. ЕБС-ИЙН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААНЫ ТАЛААРХ БШУЯ-НЫ САНААЧЛАГА

2015-17: БСШУСЯ нь ЕБС-ийн 8, 9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжааны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тэр дундаа 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн “Сонголтын 7 хоног”-ийн үйл ажиллагааг бүх сургуульд зохион байгуулсан байдаг. Энэ үйл ажиллагаатай холбоотой ЕБС-ийн удирдлага, 8,9 дүгээр ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө боловсруулж төрийн өмчийн бүх сургуулиудад түгээсэн байна.

2018-19: БСШУСЯ нь ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдад чиглэсэн ажил мэргэжлийн чиг баримжааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх санаачлага гаргаж, холбогдох удирдамж, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулж байна. Үүнтэй холбогдуулан ЕБС-ийн удирдлага, ахлах ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө, хөтөч боловсруулж, төрийн өмчийн бүх сургуульд түгээн дэлгэрүүлж ажилласан. Энэ үйл ажиллагаа 2018-2019 оны хичээлээс жилээс эхлэн бүх сургуульд хэрэгжүүлсэн.

4. СУРАЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА: СУРГУУЛИЙН ОРЧИНД БОЛОН ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ бүлэгт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын болон танхимын бус үйл ажиллагаа, сургуулиас гадуурх үйл ажиллагааны талаар, түүнчлэн энэ үйл ажиллагаанд эцэг эхийн оролцох оролцоо, үүргийн талаар авч үзлээ.

Хүүхдүүд ажил, амьдралын талаар сургуулийн орчинд болон гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан сурч мэддэг гэдгийг бид бүхэн сайн мэднэ. Ийм учраас ангийн менежментийн баг өөрийн дотоод болон гадаад нөөц, онцлогийг харгалзан өөрийн гэсэн ажил мэргэжлийн чиг баримжааны хөтөлбөр боловсруулах юм. Үүндээ эцэг эхийн оролцоог нарийн тусгаж оруулах хэрэгтэй.

Дараах хүснэгтэд 12 ангийн хүүхдүүд ажил мэргэжлийн төлөвлөлт хийхтэй холбоотой ямар мэдлэг, чадвар эзэмшсэн байх хэрэгтэй болон энэ мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр танхимын болон танхимын бус, сургуулиас гадуурх ямар үйл ажиллагаа байх талаарх мэдээллийг харууллаа.

Ажил мэргэжлийн чиг баримжааны мэдлэг, чадвар, холбогдох үйл ажиллагаа

МЭДЛЭГ, ЧАДВАР	СУРГУУЛИЙН ОРЧИНД	СУРГУУЛИАС ГАДУУР
1. Өөрийн чадвар болон ажил мэргэжлийн сонирхлын талаарх мэдлэг	-Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах - Сурлагын амжилт - Сургуулийн клуб олон сургалтыг дэмжих үйл ажиллагааны оролцох - Сургуульд сурахтай холбоотой үүргээ биелүүлэх i) Нийгмийн ажилтан ажил мэргэжлийн чиглэлээр ганцаарчлан зөвлөгөө өгөх	✓ Цагийн ажил ✓ Сайн дурын үйл ажиллагаа ✓ Ажлын туршлага хуримтлуулах үйл ажиллагаа ✓ Гэр бүлийн үүрэг, оролцоо ✓ Найз нөхдийн үүрэг, оролцоо ✓ Чөлөөт цагаараа хийх үйл ажиллагаа

	ii) Ажил мэргэжлийн сорил	✓ Хөгжим, спорт, бүжиг, урлагийн дугуйлан, секц
2. Ажил мэргэжил, ажлын ертөнц, ажилд тавигддаг хувь хүний болон мэргэжлийн шаардлага, ажил мэргэжил эзэмших олон янзын сургалтын замнал болон ажил хайх тухай мэдлэг	i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах ii) Ажил мэргэжилтэй холбоотой ном гарын авлага iii) Ажил мэргэжилтэй холбоотой вэбсайт iv) Эцэг эх, төгсөгч, ажил олгогч, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх v) Сургуульд сурахтай холбоотой үүргээ биелүүлэх vi) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын “Ажил олгогчдын шаардлага”-ын судалгаа	✓ Ажлын туршлага хуримтлуулах ✓ Цагийн ажил ✓ Гэр бүлийн үүрэг ✓ Орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд хувь нэмэр оруулах ✓ Ажлын байранд зочлох ✓ Ажил мэргэжлийн яармаг, үзэсгэлэн ✓ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ✓ Вэбсайт
3. Төрийн болон хувийн их дээд сургууль, МБС-ын байгууллага, сургууль, өдрийн, эчнээ, оройн, зайн болон ЦОС сургалтын төрлийн талаарх мэдээлэл. Энэ мэдээлэл нь хөтөлбөрийн зорилго, зорилт, тухайн хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжил, сургалтын хугацаа, зардал болон хөтөлбөрөө дүүргээд ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх агуулгатай	i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах ii) Ажил мэргэжилтэй холбоотой ном, гарын авлага iii) МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын тухай вэбсайтууд (www.mergejil.mn , www.num.edu.mn , www.msue.edu.mn гэх мэт) iv) Төгсөгч, их дээд сургуулийн оюутан, эцэг эх, сургалтын байгууллагын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх (МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын) v) МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын элсэлтийн шаардлагын тухай мэдээлэл бүхий гарын авлага, брошур vi) Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн	✓ Вэбсайтаас шаардлагатай мэдээлэл цуглуулах ✓ Сургалтын байгууллагуудын элсэлтийн талаарх мэдээлэл, гарын авлага, брошур ✓ Сургалтын байгууллагуудад зочлох ✓ Боловсролын яармаг, үзэсгэлэн ✓ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

	судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага”-ын судалгаа	
4.Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхтэй холбоотой мэдээллийг хаанаас яаж цуглуулах болон мэдээллийн эх сурвалжийг үнэлэх	i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах ii) Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх	✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх, ✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах
5.Ажил мэргэжил, сургалтын талаарх хөндлөнгийн мэдээлэл болон өөрийн чадвар, сонирхлын талаарх мэдээллийг ашиглан төлөвлөлтийг хэд хэдэн хувилбартай хийх	10-12 дугаар ангид сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш хамтран тодорхой зохион байгуулалттай үйл ажиллагааг “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах	✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх, ✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах
6.Ажилгүйдэлд бэлтгэлтэй байх	i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах ii) Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх	✓ Гэр бүл найз нөхдийн туршлага, ажиглалт ✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнийн зөвлөгөө
7.Ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл болох ажил хайх чадвар. Энд: -Өргөдөл бичих -Товч намтар, CV боловсруулах -Ажлын ярилцлага бэлтгэх -Ажил хайхад өөрийн мэдэх сүлжээг ашиглах -Ажилд зуучлах байгууллагууд -Орон нутгийн хөдөлмөрийн хэлтэс	i) Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх ii) Төгсөгч, эцэг эх болон ажил олгогчид уулзалт, ярилцлага хийх iii) Ротари клуб, Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, ТББ-тай хамтран уулзалт, ярилцлага хийх	Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтэст зочлох
8. Ажлын байранд шаардлагатай мэдлэг, чадвар: -Хөдөлмөрийн хууль,	i) Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх ii) Орон нутаг дахь Худалдаа аж	

<p>гэрээний талаар мэдэх (хүйсийн асуудлыг мөн авч үзэх) -Ажлын байрны зан үйл болон бусад шаардлага -Хөдөлмөрийн зах зээлд хэрхэн хөдөлгөөнтэй, идэвхтэй байх</p>	<p>үйлдвэрийн тэнхимийн салбар байгууллагууд танилцуулга, уулзалт, ярилцлага хийх</p>	
<p>9.Хувиараа хөдөлмөр болон аж ахуй эрхлэх</p>	<p>i) Ротари клуб эсвэл Худалдаа аж үйлдвэрийн тэнхимтэй хамтран хувиараа аж ахуй, хөдөлмөр эрхлэгчийг урьж уулзалт, ярилцлага хийх</p> <p>ii) Суралцагчдын дунд “мини-аж ахуй эсвэл компани” үүсгэх, удирдахад дэмжлэг үзүүлэх клубууд ажиллуулах</p>	

Эцэг эхийн үүрэг:

Эцэг эхчүүд ямар ажил мэргэжилтэй, ажил хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүйгээс үл хамааран сургуулийн ажил мэргэжлийн чиг баримжааг хэрэгжүүлэхэд, суралцагчдад ажил мэргэжил, ажлын ертөнц, тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай боловсрол, сургалтын талаар мэдээлэл өгөхөд чухал эх сурвалж, нөөц болж чадна. Эцэг эхчүүд 12 ангийн ажил мэргэжлийн чиг баримжаанд дараах чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжтой.

СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ

- Анги танхимийн үйл ажиллагаанд ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгөх, өөрийн туршлагаасаа хуваалцах
- Сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтанд хаана, хэнд ажил мэргэжлийн эх сурвалж, нөөц байдаг, үүнийг яаж ашиглах талаар зөвлөгөө өгөх, санал тавих
- Сургуулийн удирдлага, багш болон эцэг эхийн зөвлөлөөр баталсан Зөвлөн туслах зөвлөлтэй хамтран сургуульд суурилсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад оролцох
- Сургуулийн түвшний ажил мэргэжлийн чиг баримжааны хэрэгжилтэд хяналт тавих
- Сургуульд ажил мэргэжлийн чиг баримжааны эх сурвалж, нөөцийг санал болгох
- Суралцагчдад ажлын туршлага судлах, ажиглалт хийх боломжийг олгох
- Суралцагчдад бодит ажлын байр, МБС болон их дээд сургуулийг танилцуулах зорилгоор зорчуулахад багшийн туслахаар ажиллах

5. ХҮҮХДЭДЭЭ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХЭД ТУСЛАХ – ЮУ ХИЙХ, ХИЙХГҮЙ ТУХАЙ

Эцэг эхчүүд болон гэр бүлийн гишүүд хүүхдийн ахлах ангийн хичээл сонголт, 12 дугаар анги төгссөний дараах боловсрол, сургалт болон ажил мэргэжлийн сонголтод хамгийн их нөлөөтэй байдаг. Зарим эцэг эхчүүд хүүхдийн сонголтод их нээлттэй ханддаг, зарим нь хүүхдийнхээ сонголтыг ерөөс сонирхдоггүй. Зарим эцэг эхчүүд хүүхэдтэйгээ энэ талаар ярилцаагүй байсан ч хүүхдүүд нь эцэг эхийнхээ үй хөдлөл, ярианаас юу сонгох хэрэгтэйгээ ойлгосон байдаг. Эцэг эхийн нөлөө заримдаа эерэг үр дүнг авчирдаг заримдаа сөрөг үр дүнтэй байдаг.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр аливаа зүйлс өөрчлөгддөг. Бидний хүүхэд эдийн засгийн, ажил хөдөлмөрийн өөр орчин, өөр нөхцөлд ажиллаж, амьдрах болно. Бидний үеийн хөдөлмөрийн зах зээлийн өнгө төрх хүүхдүүдийн үед өөр байх болно. Бидний мэддэг ажил мэргэжлийн боломжууд тэднийг ажил хөдөлмөр эрхлэх үед байх боломжтой нийцэхгүй болно.

Дараах хүснэгтэд эцэг эхчүүд хүүхдүүддээ ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой зөвлөгөө өгөхөд туслах зарим санааг үзүүлээ. Эдгээр нь эцэг эх хийж болох бас хийж болохгүй гэж ангилагдсан болно!

ХҮҮХДЭДЭЭ ХЭРХЭН ТУСАЛЖ ДЭМЖИХ БОЛОН ХИЙЖ БОЛОХ ЗҮЙЛС

- Тэдэнд өөрийн хүйс болон уламжлалд баригдалгүйгээр бүх ажилд ач холбогдол өгөхөд туслах
- Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах боловсрол, сургалтын бүх боломжид ач холбогдол өгөхөд туслах
- Тэдний ажил мэргэжлийн талаарх мөрөөдлийг бүү няцаа, сургуулийн орчны болон гадуурх ажил мэргэжлийн чиг баримжааны үйл ажиллагаагаар дамжуулан хүсэж, мөрөөдөж буй ажил мэргэжилтэй холбоотой бүх асуудлын талаар судалж мэдэх, таньж мэдэхэд хүүхдэдээ дэмжлэг үзүүлэх
- Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхэд сургуулийн орчны болон гадуурх нөөц боломжийг сайн мэддэг байх
- Ажил мэргэжилтэй холбоотой боловсрол сургалтын бүх төрлийн (МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын өдрийн, эчнээ болон оройн сургалт, төрийн өмчийн болон хувийн) боломжийн талаар сайн мэддэг байх
- Суралцагчийн гарын авлага, ажил мэргэжлийн төлөвлөлтийн агуулгатай танилцаж, сайн мэддэг байх
- Хүүхэдтэй хамт суралцагчийн гарын авлагын дасгалыг ажиллах
- Их дээд сургуулийн элсэлтийн шалгалтад бус хүүхдийнхээ ажил мэргэжлийн сонголтод анхаарал хандуулах
- 12 дугаар анги төгссөний дараах ажил хөдөлмөр, боловсрол, сургалтын бүх боломжийг авч үзэх, зөвхөн их дээд сургууль гэж туйлшрах хэрэггүй
- Сургуулиас зохион байгуулах эцэг эхэд зориулсан ажил мэргэжлийн мэдээллийн уулзалтад идэвхтэй оролцох
- Хүүхдээ сонирхож буй ажил мэргэжлийн талаар мэдээлэл цуглуулах, туршлага судлах, энэ чиглэлээр сургуулийн орчны болон гадуурх үйл ажиллагаанд оролцоход дэмжих
- Хүүхдээ ажил мэргэжлийн, боловсрол, сургалтын талаар олон хувилбартай сонголт хийхэд туслах
- Хүүхдээ тэвчээртэй сонсох, асуулт асуух

- Хүүхдийнхээ ажил мэргэжилтэй холбоотой зарим асуултад шууд бэлэн хариулт хэлж өгөхөөс илүүтэй энэ асуултын хариултаа өөрөө олж мэдэхэд дэмжлэг үзүүлэх, асуултынхаа талаар судлах, олж мэдсэн хариултаа эцэг эхдээ мэдээлэх үүрэг өгөх
- Хүүхдийнхээ сонирхож буй ажил мэргэжил болон холбогдох боловсрол, сургалтын талаарх зарим асуултад өөрийн чадах хэрээр сайн хариулах, хэрэв хариулж мэдэхгүй бол энэ талаар хүүхэдтэйгээ хамт судалж, эрэл хайгуул хийх
- Ажил мэргэжлийн янз бүрийн сорил ашиглан хүүхэддээ сонирхож буй ажил мэргэжлийн чиглэлээр өөрийнх нь чадвар, үнэт зүйл нь тухайн ажлын шаардлагатай нийцэх эсэх талаар таньж мэдэхэд туслах
- Хүүхдийнхээ сонирхож байгаа ажил мэргэжил, боловсрол, сургалтын цаашдын төлөвийн талаарх өөрийнхөө итгэл үнэмшлийг шалгаад үз, энэ чиглэлээр боловсрол, сургалтын байгууллагад суралцаж төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статистикийг судлах, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээний талаар анхааралтай судлах (энэ мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтаас жил бүр хэвлүүлдэг тайлангаас авч болно)
- Ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээл, боловсрол, сургалтын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээ, нэвтрүүлгийг анхааралтай сонсох
- Хүүхэдтэйгээ хамтран ажиллах, тэдэнд зөвлөх, дэмжлэг үзүүлэх,
- Анги удирдсан багш, нийгмийн ажилтантай нь шаардлагатай бол зөвлөлдөх
- Шаардлагатай бол хүүхдээ дагуулаад сонирхож буй ажил мэргэжлийн чиглэлийн байгууллагад очиж ажлын нөхцөл, орчинтой танилцаж, холбогдох мэргэжилтэн, ажилтантай уулзах, ажлын байранд богино хугацаанд ажиглалт хийж, дүгнэлт хийхэд дэмжлэх үзүүлэх
- Сонирхсон ажил мэргэжилтэй холбоотой боловсрол, сургалтын байгууллагад хүүхэдтэйгээ хамт очиж, суралцах орчин, сургалт, мэргэжлийн хөтөлбөрийн ялгааны талаар холбогдох мэргэжилтэн, оюутан, суралцагчидтай уулзаж ярилцах

ХИЙЖ БОЛОХГҮЙ ЗҮЙЛ

- Хүүхдийн ажил мэргэжлийн талаарх санал бодол, хүсэл сонирхлыг бүү няцаа, үгүйсгэ! Сонирхож буй ажил мэргэжлийн талаар өөрөө судалж мэдэх, өөрийнхөө нөөц боломжийн хязгаарыг танихад дэмжлэг үзүүл!
- Ажил мэргэжлийн талаарх өөрийнхөө төсөөлөл, өнгөц дүгнэлтийг бүү хэл!
- Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хүүхдэдээ бүү тулга!
- Өөрийнхөө биелүүлж чадаагүй хүсэл мөрөөдлөө хүүхдээрээ хийлгэх гэж бүү оролд!
- Тэдний хүсэл сонирхлыг хэтэрхий бүү хяна!
- Тэдний өмнөөс дангаараа бүү шийдвэр гарга!
- Тэдэнд хэтэрхий их нөлөөлөх гэж бүү оролд!

Модуль боловсруулахад болон хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, ном зүй:

Гарын авлага: АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018

- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

Цахим эх сурвалж:

www.myfuture.mn

<https://mergeil.mn>

<http://num.edu.mn>

<http://msue.edu.mn>

<http://rilsp.gov.mn>

<https://www.careers.govt.nz/jobs-database/>

<https://nationalcareersservice.direct.gov.uk/job-profiles/home>

<https://www.onetonline.org/find/family>

<http://hudulmur-halamj.gov.mn/occ>

<http://jobclass.ubstat.mn/>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ